МБМ

МОНЦЕМЕНТ БИЛДИНГ МАТЕРИАЛС ХХК

# ТАНИЛЦУУЛГА

Монцемент Билдинг Материалс ХХК (МБМ) нь Монполимет Групп болон Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны (EBRD) хөрөнгө оруулалт, дэмжлэгтэйгээр Монгол улсын хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль эрх зүйн хүрээнд үүсэн байгуулагдаж төслийн үе шатнаас бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бие даасан шат хүртэл үйл ажиллагаагаа амжилттай явуулж буй компани юм.

МБМ ХХК нь Дорноговь аймгийн Өргөн суманд 2015 онд дэлхийн хамгийн орчин үеийн дэвшилтэт, эко технологиудыг нэвтрүүлсэн жилийн 1.000.000 тонн цемент, цементийн клинкер үйлдвэрлэх хүчин чадал бүхий хуурай аргын цогц үйлдвэрийг барьж байгуулан ашиглалтанд оруулаад байна. Түүнчлэн энэхүү үйлдвэрийн нэг хэсэг болох цагт 120 тонн цемент үйлдвэрлэх хүчин чадал бүхий клинкер боловсруулах үйлдвэрийг Улаанбаатар хотын СХД-ийн нутаг дэвсгэрт барьж байгуулсан нь аж үйлдвэрийг цогцолбороор хөгжүүлэх үлгэр жишээ загвар гэж хэлж болохоор байна.






## БИДНИЙ АЛСЫН ХАРАА:

Бид тэргүүлэх зэрэглэлийн чанар, найдвартай, тогтвортой үйлчилгээ, үлгэр жишээ нийгмийн хариуцлага бүхий шилдэг хамт олон байж **САЙХАН ИРЭЭДҮЙГ БҮТЭЭН БАЙГУУЛНА.**

## БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛТУУД:

### ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛООР ТЭРГҮҮЛЭХ (ЛОЖИСТИК)

- Бүтээгдэхүүнээ хамгийн хурдан, шуурхай замаар хэрэглэгчиддээ хүргэх, үйлчилгээний стандартыг олон улсын түвшинд хүргэж хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг баталгаажуулна.

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ҮНЭЛЭМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

- Эх орондоо, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд ашигтай нөхцлийг бүрдүүлсэн бүгдэд хүртээлтэй эдийн засгийн өсөлтийг бий болгоно.

### ЧАНАРААР МАНЛАЙЛАХ (ISO)

- Бид үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийхээ чанарыг тасралтгүй хөгжүүлж барилгын салбарын насжилтыг нэмэгдүүлнэ.

### ШИЛДЭГ ТУРШЛАГА БА ШИНЭ САНААГ ДЭМЖИХ (R&D)

- Байнгын судалгаа, бүтээгдэхүүн хөгжүүлэлт болон хөрөнгө оруулалт дээр тулгуурлан бүтээгдэхүүнээ төрөлжүүлж өргөжүүлнэ.



# МОНЦЕМЕНТ ҮЙЛДВЭРИЙН ДАВУУ ТАЛ:

- 1000 гаруй мэргэжлийн ажиллах боловсон хүчин, инженер техникийн ажилчдыг ажлын байраар хангаж, алслагдсан орон нутагт шинээр мэргэжлийн ур чадвар шаардах ажлын байр бий болгосон.
- Өндөр чанарын түүхий эдээр үйлдвэрлэсэн бүх төрлийн цемент.
- Монгол улсын төмөр замын сүлжээтэй ойр байршилтай, 3,5 км өөрийн салаа төмөр замтай.
- Задгай цемент тээвэрлэх зориулалт бүхий Европ стандартын өөрийн хоппер вагоны баазтай.
- Тасралтгүй, найдвартай, зогсолтгүй ажиллах хүчин чадал бүхий бүрэн автоматжуулагдсан үйлдвэрлэлтэй.
- Чанарын хяналтын менежментийг өөрийн бүрэн тоноглогдсон итгэмжлэгдсэн лабораториор найдвартай хянах хөтөлбөртэй.
- Дэлхийн цементийн үйлдвэрлэлийн туршлагатай мэргэжилтнүүдийн мэдлэг туршлагыг ашигладаг.
- Олон нэр төрлийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн сэтгэлд нийцэх арга замуудаар нийлүүлэх хүчин чадалтай.



## WHR ТЕХНОЛОГИ ХАЯГДАЛ ХАЛУУН ХИЙГ АШИГЛАН **5мвт** эрчим хүч үйлдвэрлэдэг

- Бүтээгдэхүүний чанарын хяналтын иж бүрэн **лаборатори болон систем**
- Эргэлтийн усны **90%**-г боловсруулан дахин ашиглах ус цэвэршүүлэх нэгдсэн систем.
- **Microsoft Dynamics 365 BC ERP** системийг амжилттай нэвтрүүлэн, захиалгын апплейкшн хөгжүүлэлт хийн хэрэглэгчид захиалгын байршилаа **realtime** харах боломжтой **GPS** систем нэвтрүүлсэн.

## ХУУРАЙ АРГЫН ЭКО ТЕХНОЛОГИ:

- Усны хэрэглээ нойтон аргын технологиос **5 дахин бага**
- Эрчим хүчний зарцуулалт нойтон аргаас **30%-р бага**
- Тоос ялгаруулалт, NO,SO-н хэмжээ **30 мг/ Нм-аас бага**
- Түлш зарцуулалт нойтон аргаас **2 дахин бага**

# ЧАНАР СТАНДАРТ:

- Олон улсын **ISO9001:2015**, **ISO45001:2018** стандарт
- Монгол улсын **MNS 3091**, **0974:2008** стандарт
- “**MNS EN197-1**, **EN 197-2** Тохирлын үнэлгээ” Олон улсын стандартын шаардлагад бүрэн нийцсэн бүтээгдэхүүн

International Organization for Standardization ISO 9001 : 2015

International Organization for Standardization ISO 45001 : 2018

EUROPEAN NORM EN



# БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРӨЛ




**CPC 32.5**

- Эрдэс идэвхт нэмэлт болон сайн чанарын гөлтгөнөтэй холин тээрэмдэх замаар гарган авсан цемент юм. Тус цемент нь бат бэхийн ангийн цемент бөгөөд ахуйн хаусны суурь, бетон хийц, шавардлага болон өрлөгт ашиглах бүрэн боломжтой.




**OPC 42.5**

- Бүх төрлийн барилга угсралт болон замын ажил, мөн дотоод засал чимэглэлийн ажлуудад өргөнөөр хэрэглэгддэг. Бат бэхийн ангилал нь 42.5 МПа (400 кг/см2)




**PC 42.5**

- Барилгын өргөн хэрэглээний зориулалттай бетон, төмөр бетон хийц, угсармал хийц, гүүр далангийн барилга, цутгамал бүтээц, зам барилгад өргөн ашиглагдана. Мөн барилгын төрөл бүрийн зуурмаг бэлтгэх, барилгын засвар, шавардлагын ажилд ашиглана. Бат бэхийн ангилал нь 42.5 МПа (400 кг/см2)




**PC 52.5**

- Өндөр бат бэх бүхий угсармал хийц, урьдчилан хүчитгэсэн бүтээц, төмөр замын бетон дэр, харьцангуй өндөр ачааллалд ажиллах төмөр бетон цутгамал байгууламж, өндөр хүчдэлийн шон, зам гүүр зэрэгт хэрэглэгдэнэ. Энэхүү цементийн бат бэх нь 52.5 МПа (600 кг/см2)

## БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДАВУУ ТАЛ:

- Эрдсийн идэвхит нэмэлт хэрэглэсэн тул ус тэсвэрлэх, сульфатын давстай орчинд тэсвэрлэх чадвар өндөртэй.
- Клинкер алитлаг, мөн цементийн хувийн гадаргуу өндөр тул уураар жигнэж боловсруулахад идэвхтэй.
- Бат бэхийн хэлбэлзэл харьцангуй бага байдгаас хэрэглэхэд тохиромжтой.
- Бетон хийц хийхэд хүйтний нэмэлт, хүчил, шүлтийн болон бусад нэмэлт нэмж хэрэглэх бүрэн боломжтой.
- Удаан жилийн эдэлгээнд бат бэхийн чанараа хадгална.

## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИ:

- Эрдэст нэмэлт - **10%**
- Нунтаглал **R008%<3**
- Хувийн гадаргуу **S см2/гр >3200**
- Ээлхүүний өөрчлөлт - **байхгүй**



## ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ:

Монгол улсдаа барилгын материал үйлдвэрлэлээрээ тэргүүлэгч хамт олон байж илүү сайхан Монголыг бүтээн байгуулах алсын хараатай, чадварлаг, туршлагатай ажиллах боловсон хүчнийг бий болгохын тулд дараах бодлогыг баримтлан ажиллаж байна. Үүнд:

- Эдийн засгийн тогтвортой хөгжил, бизнесийн таатай орчин нөхцөлийг хангахад хууль ёсыг дээдэлсэн хариуцлагын ил тод тогтолцоог бүрдүүлж, хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээх компанийн зохистой удирдлагын зарчмуудыг хэрэгжүүлж байна.
- Компанийн сайн засаглалыг хөгжүүлж эдийн засгийн нээлттэй, тогтвортой байдлыг хангахаар зорьж байна.
- Олон улсад хэрэглэгддэг хүний нөөцийн шилдэг арга туршлагаар чадварлаг ажилчдыг эгнээндээ нэгтгэн ажлын байраар хангаж байна.
- Бусдыг хүндэтгэх, хүйсийн эрх тэгш байдлыг хангахад онцгой анхаарч байна.

## АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХӨГЖҮҮЛЭЛТ:

Манай компани ажилчдынхаа хувь хүний хөгжил болон ур чадварыг дээшлүүлэх зорилготойгоор сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажилладаг. Компани нь ажилчиддаа инженерийн тусгай болон ур чадварыг дээшлүүлэх сургалтуудыг санал болгодог. Үүнд:

- Гадаад улс оронд адил төрлийн цементийн үйлдвэрлэл эрхлэгч компаниудтай нягт хамтран ажиллаж, олон улсын мэргэжилтнүүдээр өөрийн ажилчиддаа зориулсан арга зүйн болон ур чадварын сургалт авдаг.
- Дотоодын их дээд сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн онол практик хосолсон сургалтуудад хамруулдаг.
- Цемент үйлдвэрлэлийн дотоодын туршлагатай мэргэжилтнүүдээр өөрийн ажлын байран дээрх сургалтуудыг зохион байгуулдаг.



# ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГУУД

ТАВАН БОГД ГРУПП
ТАВАН БОГД ПРОПЕРТИ ХХК
Хамтын хүч - Амжилтын түлхүүр

ТЕХНИК ИМПОРТ
ХУВЬЦААТ КОМПАНИ

ЦАХИУР ГРУПП

NAR URT

MONGOLIANTRANS
LOGISTIC

УБ БҮК
УЛААНБААТАР БҮК ХК

ТУНАМАЛ МАЙНД ХХК

БАТ БЭХ РЕМИКОН

РЕМИКОН ХК

TTC&T
LIMITED LIABILITY COMPANY

САЛБАРТ ТРЕЙД

САЙХАН ХАРАА

IRIS PARTNERS
CONCRETE

PREMIUM
Building Materials

ORGIL ZUURMAG

ТҮМЭН ТӨМӨРТ

ZAG
SINCE 1991

ХАС ХОС ОЧИР ХХК

САН РЕМИКОН

ДЭЛГЭР БАЯСАХ ЗАМ

CITY MENT
СИТИМЕНТ ХХК
ШИНЭ ХОТЫГ ХАМТДАА БҮТЭЭЕ

NCD PRECON

GANTULGA
TRADE

ТЭНГЭРИЙН ДОЛООН ОД ХХК

Ashid Bekhi

ОПТИМА Конкрет ХХК

AKUMA

НУТГИЙН БУЯН ГРУПП ХХК

# ҮЙЛДВЭР, БОРЛУУЛАЛТЫН ЦЭГҮҮД:



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМ



УЛААНБААТАР ХОТ 22-Н ТОВЧОО

- ТАЛХИЛТ, ОРБИТЫН УУЛЗВАР
- ЦАЙЗ ЗАХ
- БАЯНХОШУУ ТОЙРОГ
- ДАРЬ ЭХ
- НИСЭХИЙН ЭЦЭС, ЯАРМАГ
- ХАНГАЙ ЗАХ
- 32-Н ТОЙРОГ
- ЦАЙЗ ЗАХ

БОРЛУУЛАЛТЫН ӨРГӨН ЦЭГҮҮД

APPSTORE

PLAYSTORE

МОНЦЕМЕНТ




## ХОЛБОО БАРИХ:

**БОРЛУУЛАЛТЫН АЛБА**: 7712-3399

**ХАЯГ**: СХД 20-р хороо, Товчооны 24,
Монцемент Улаанбаатар үйлдвэр